

## Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.26 2019.04



### Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал сургалт зохион байгуулагдлаа (2019.04.02)

2019 оны 3 дахь удаагийн Хөгжлийн бэрхшээлийн тухай хичээл 3/27-ны өдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хичээлийн зорилго нь сонголын бэрхшээлтэй иргэд хэрхэн хөдөлгөөн өрнүүлж ирсэн тухай, Дэлхийн сонголын бэрхшээлтэй иргэдийн холбоо болон Японы



Оролцогчидтой санал солилцов

сонголын бэрхшээлтэй иргэдийн холбоо ямар үйл ажиллагаа явуулж ирсэн түүхээс суралцах явдал байв. Тус хичээлд сонголын бэрхшээлтэй олон хүмүүс хамрагдсан ба нийт 70 гаруй хүмүүс идэвхтэй оролцлоо. Сургалтын үеэр сонголын бэрхшээлтэй иргэдийн хувьд дохионы хэл, дохионы хэлний орчуулагч нь ямар чухал болох, мөн боловсрол, мэдээлэл авах гэх мэт эрхээ баталгаажуулахын тулд сонголын бэрхшээлтэй иргэд ямар үйл ажиллагаа явуулж ирсэн тухай түүхийг танилцуулав. Үүнээс гадна Монголын сонголын бэрхшээлтэй иргэдийн эрх хэр түвшинд хамгаалагдаж байгаа талаар оролцогчидтой санал солилцлоо. Сургалтаас сонголын бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх бүрэн хангагдаагүй байгаа гэдгийг ойлголоо. Учир нь дохионы хэлээр боловсрол, хос хэлний боловсрол, сурагчдад мэдээлэл дамжуулах аргачлал нь хангалтгүй байгаа учраас ердийн сургуультай ижил хэмжээний боловсрол эзэмших эрх хангалтгүй байгаа гэж бодож байна. Энэ удаагийн хичээлээр цаашид ч гэсэн сонголын бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудтай санал солилцох шаардлагатай гэдгийг ойлголоо. Боловсрол, мэдээллийн хүртээмжийг сайжруулахын тулд DPUB төсөл холбогдох үйл ажиллагаануудыг үргэлжлүүлэн

### Тайланд дахь сургалтын тайлангийн хурал (2019.04.01)



Сургалтын оролцогчид

Монголын ХБИ-ийн ТББ-уудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой Тайланд дахь сургалтын тайлангийн хурал 3/4-ний өдөр зохион байгуулагдлаа. Тайландын хувьд хөгжлийн бэрхшээлийн төрөл, ТББ-уудын үйл ажиллагаа нь өөр хоорондоо ялгаатай ч “нийтлэг эрх ашиг”-аа тодорхойлж чадсанаар

хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, бодлогын түвшинд дуу хоолойгоо хүргэх болж, ХБИ-ийн нийгмийн халамжийн бодлогыг сайжруулж ирсэн түүхтэй. Монголд ч гэсэн ТББ-ууд хамтран ажиллах бүрэн боломжтой. Семинарын үеэр оролцогчид Монголын ХБИ-ийн ТББ-ууд тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг, өмнө нь нэг удаа нэгдсэн боловч амжилтгүй болсон, манлайлагч байхгүй, зөвхөн өөрт ашигтай зүйлийг л хүсэж шаарддаг хүмүүс олон гэх мэт тулгамдаж буй асуудлуудыг ярьж байв. Нөгөөтэйгүүр ХБИ-ийн ТББ-ууд нэгдэн бодлогын түвшинд хэлэлцэх хэрэгтэй, хөгжлийн бэрхшээлийн төрөл хамаарахгүйгээр хамтран ажиллах ёстой, ХБИ-ийн ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай зэрэг хамтын ажиллагаа, нэгдэлтэй холбоотой олон эерэг саналуудыг ч дэвшүүлж байлаа. Аль ч улс оронд ХБИ-ийн ТББ-ууд нэгдэн ажиллах нь хэцүү боловч нэгдэл, хамтын ажиллагаа сайн байгаа орнуудад төр, ТББ-ууд амжилттай хамтран ажиллаж байна. DPUB төслийн зүгээс цаашид ХБИ-ийн ТББ-ууд хамтран ажиллах тогтолцоог бий болгох, мөн төр, ТББ-уудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллах болно.

### Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв~Үйлчлүүлэгч нэг бүрт ээлтэй байгууллага болохыг зорилт болгоно (2019.04.11)



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, мөн хоёр орны

харилцаа, хамтын ажиллагааг холбох гүүр болон ажиллаж байна. Төвийн зүгээс сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг ба номын сангаар нь өдөр тутам олон хүмүүс үйлчлүүлдэг. Тус төв нь 17 жилийн өмнө байгуулагдсан бөгөөд орох хаалганы хэсэгт налуу зам хийхээс гадна тэргэнцэртэй хүмүүс хэрэглэхэд тохиромжтой түгээмэл загварын ариун цэврийн өрөөтэй гэх мэтчилэн анхнаасаа л “хүртээмжтэй орчин”-г бүрдүүлэх тал дээр анхаарал хандуулж иржээ. “Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчид нэмэгдэхийн сацуу төрөл бүрийн хэрэгцээ шаардлагатай хүмүүс үйлчлүүлэх болсон. Тиймээс зөвхөн барилга байгууламж бус ажилчдынхаа үйлчилгээг ч сайжруулмаар байна” хэмээн номын сангийн ажилтан ярьж байсан юм. Иймээс тус төвийн албан хаагчдад зориулж хөгжлийн бэрхшээлийн тухай сургалт зохион байгууллаа. Эхлээд хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт өгөх “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)”-ыг зохион байгуулсан ба дараа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн туслах аргачлалын талаар сургалт явууллаа. Оролцогчид “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт маань өөрчлөгдсөн. Сургалтын арга хэлбэрийн хувьд практик дасгал түлхүү орсон байсан нь сонирхолтой байлаа” хэмээн сэтгэгдлээ илэрхийлж байв. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө сургалт явуулсан нь урам зориг төрүүлсэн бололтой. Энэ удаагийн сургалтыг төвийн монгол ажилтан санаачлан зохион байгуулсан бөгөөд оролцогчид ач холбогдол өгөн идэвхтэй хамрагдаж байсан нь сургалт үр дүнтэй болоход нөлөөлсөн төдийгүй сургагч багш нарт ч хамтарч ажиллахад таатай байлаа.



Сато Кацүши багш

### Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах семинар-2 (2019.04.01)

3-р сарын 12-ны өдөр “Дэд бүтцийн хүртээмжийн семинар -2”-ыг зохион байгуулсан бөгөөд Японоос Сато Кацүши багш урилгаар оролцов.

*Монголд яагаад хэт огцом налуу шат олон байдаг вэ?*

Үүний нэг шалтгаан нь барилгын зураг төсөлд налуу замаас бусад дэд бүтцийн хүртээмжийг тусгадаггүй явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, догол, саадгүй зам, зориулалтын автомашины зогсоол, өндөр барилга доторх цахилгаан шат зэргийг зураг төслийн шатанд тусгаагүй байдаг учраас ашиглалтанд орсон барилгын хүртээмжтэй орчин хангалтгүй байдаг байна. Иймээс зураг төслийн шатнаас нь хүртээмжтэй болгохын тулд магадлал хийх үйл явц, тогтолцоотой холбоотой Японы хууль эрхзүй, стандартаас суралцах зорилгоор энэ удаагийн семинарыг зохион байгууллаа. Семинарт холбогдох төрийн байгууллагынхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд нийт 100 гаруй хүн оролцов.



Хэлэлцүүлгийн үеэр

Магадлал хийх үйл явц нь учир дутагдалтай гэдгийг ойлгосон боловч ХБИ-ийн ТББ-уудын зүгээс дэд бүтцийн хүртээмжтэй орчныг бүрдүүлэх ажлууд хэдэн жилийн турш ахицгүй байгаа, төрийн байгууллагынхан хуулиа ягштал биелүүлэх ёстой гэх мэт хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг ч дуртацгааж байв. Монголд ХБИ, өндөр настан, жирэмсэн эхчүүд болон хүнд ачаа зөөж байгаа хүн гэх мэт бүх хүмүүст ээлтэй орчныг бүрдүүлэхэд нэлээдгүй хугацаа шаардлагатай. Гэхдээ энэ удаагийн семинараар шалтгаан, шийдвэрлэх арга замуудыг тодорхой болгож чадлаа. DPUB төслийн зүгээс цаашид БХБЯ, ЗТХЯ-уудтай хамтран зураг төслийн шатнаас нь хүртээмжтэй болгох асуудалд анхаарал хандуулан ажиллах болно.

### ЖАЙКА-ийн мэргэжилтнээр ажиллах болсон шинэ сорилт



Ахлах зөвлөх Чива Хисао

2002 оны 7-р сараас анх удаа ЖАЙКА-ийн мэргэжилтнээр ажиллахаар боллоо. Улмаар Бангкок хотод байдаг “Ази, Номхон далайн бүсийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв (APCD)”-д томилогдон очив. APCD нь НҮБ-ын “Ази, Номхон далайн бүсийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 жил”-ийн хэрэгжилтийг хангах, үргэлжлүүлэх зорилгоор байгуулагдсан юм. Тус байгууллага нь 1) Ази, Номхон далайн бүсийн орнуудын Засгийн газар, ТББ-уудын сүлжээг бий болгох 2) Хүний нөөцийг бэлтгэх, сургалт явуулах 3) Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн төв, Мэдээллийн хүртээмж гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байв. ЖАЙКА-аас 4 мэргэжилтэн томилогдсоны 1 нь би байлаа. Тухайн үед би Хөгжлийн бэрхшээл болон Олон улсын хамтын ажиллагааны салбарт ажилласан туршлага багатай байсан учраас ажиллах явцдаа мэргэжлийн мэдлэг, туршлагатай бол болохгүй нь ээ гэсэн сэтгэгдэлтэйгээр ажлаа эхлүүлж байснаа санаж байна. Би Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн төв, Мэдээллийн хүртээмж, Мэдээллийн сургалтыг хариуцаж байлаа. Эхэн үед үйл ажиллагааны агуулга маань тодорхой болоогүй байсан тул юуны өмнө Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд компьютер гэх мэт мэдээлэл, харилцааны хэрэгслийг хэр түвшинд хэрэглэж байгааг судлах ажлыг эхлүүлсэн. Тухайн үед хөгжиж буй орнуудад ч гэсэн интернет зэрэг харилцаа холбооны дэд бүтэц нэвтэрч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч мэдээллийн технологийг ашиглаж эхэлж байлаа.

ЖАЙКА DPUB фэйсбүүк хуудсанд

**LIKE** дарж нэгдээрэй!!



Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **4682** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

### DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)